

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2011 оны 173/2 дугаар хамтарсан тушаалын хавсралт



**ХИЛИЙН ЧАНАДАД АМЬДАРЧ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН  
ИРГЭНД ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ЛАВЛАГАА ОЛГОХ  
ХЯЛБАРЧИЛСАН ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Энэхүү журмаар хилийн чанадад амьдарч байгаа Монгол Улсын иргэн үндэсний гадаад паспорт, иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээгээ үрэгдүүлсэн тохиолдолд түүнийг шинэчилсэн бүртгэлд бүртгэхтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газраас иргэний бүртгэлийн лавлагааг хялбаршуулсан журмаар олгох, Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар лавлагааг үндэслэн төрсний бүртгэлийн гэрчилгээг шинээр олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

**Хоёр. Хилийн чанадад амьдарч байгаа иргэн  
иргэний бүртгэлийн лавлагаа авах хүсэлт гаргах**

2.1. Хилийн чанадад амьдарч байгаа Монгол Улсын иргэн үндэсний гадаад паспорт, иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ нь байхгүй тохиолдолд иргэний бүртгэлийн /төрсний бүртгэлийн/ лавлагаа авах хүсэлтээ Улсын бүртгэлийн ерөнхий газрын [www.registrationmongolia.com/gad\\_lavlagaa](http://www.registrationmongolia.com/gad_lavlagaa) буюу [www.burtgel.mn/gad\\_lavlagaa](http://www.burtgel.mn/gad_lavlagaa) цахим хуудас дахь лавлагааны цонхонд хандаж ирүүлнэ.

2.2. Иргэн төрсний бүртгэлийн лавлагаа авах хүсэлтийг ирүүлэхдээ цахим хуудас дахь мэдээллийн цонхыг бүрэн гүйцэд, үнэн зөв бөглөнө.

**Гурав. Улсын бүртгэлийн ерөнхий газраас  
иргэний бүртгэлийн лавлагаа олгох**

3.1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний баримтын архивын гадаад лавлагаа хариуцсан мэргэжилтэн иргэний лавлагаа гаргуулах тухай хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч, дэс дугаарын дагуу бүртгэн авна. Бүртгэн авахдаа иргэний хүсэлт гаргасан огноо болон бусад мэдээллийг нэгбүрчлэн тэмдэглэнэ.

3.2. Иргэний баримтын архивын гадаад лавлагаа хариуцсан мэргэжилтэн лавлагаа хүссэн иргэдийн хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын 5 өдрийн дотор лавлагааг гаргаж, гарсан лавлагааг /төрсний болон иргэний үнэмлэхийн/ эх хувиар нь сканердан тухайн иргэний оршин суугаа улсын Монгол Улсаас хийлийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын иргэний бүртгэл хариуцсан консулын ажилтанд цахим шуудангаар илгээж, бүртгэлд хүргүүлсэн огноо, цагийг тэмдэглэнэ.

Иргэний төрсний бүртгэлийн лавлагааг иргэний үнэмлэхийн зурагтай лавлагаатай заавал хамтад нь хүргүүлнэ.

3.3. Иргэний баримтын архивын гадаад лавлагаа хариуцсан мэргэжилтэн лавлагааны хариу гарсан эсэх талаар иргэнд цахим хаягаар нь хариу мэдэгдэнэ. Хэрвээ лавлагаа гарах боломжгүй тохиолдолд иргэнд хариу илгээж шаардлагатай нэмэлт мэдээллийг авна.

Сканердаж илгээсэн лавлагааг эхээр нь нэгтгэн, нэрийн жагсаалтын / улс бүрээр нь нэгтгэн/ хамт Иргэний бүртгэлийн газрын хариуцсан улсын бүртгэгчид сар бүр бүртгэлээр хүлээлгэн өгч гарын үсэг зурж баталгаажуулна.

### **Дөрөв. Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар иргэний бүртгэлийн лавлагааг хүлээн авах**

4.1. Хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газрын иргэний бүртгэл хариуцсан консулын ажилтан Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний баримтын архивын гадаад лавлагаа хариуцсан мэргэжилтний ирүүлсэн төрсний болон иргэний үнэмлэхийн зурагтай цахим лавлагааг хүлээн авч бүртгэн, лавлагааг хэвлэн гаргаж, гарын үсэг зурж, тэмдэг даран давхар баталгаажуулж ирсэн хугацааг тэмдэглэж баримтжуулна.

4.2. Иргэний үнэмлэхийн зурагтай лавлагааг тухайн иргэний дүр төрх бусад мэдээлэлтэй тулган шалгаж зөрүүгүй тохиолдолд төрсний бүртгэлийн лавлагааг үндэслэн төрсний гэрчилгээг шинээр бичиж олгон иргэнийг иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгэнэ.

4.3. Төрсний лавлагаагүйгээр иргэнд төрсний гэрчилгээг шинээр бичиж олгохыг хориглоно.

### **Тав. Бусад**

5.1. Иргэний шинэчилсэн бүртгэлийн ажлын хүрээнд хилийн чанадад амьдарч байгаа Монгол Улсын иргэнээс цахим шуудангаар ирүүлсэн хүсэлтийг үндэслэн олгож байгаа төрсний бүртгэлийн болон иргэний үнэмлэхийн зурагтай лавлагааг үнэ төлбөргүй олгоно.

5.2. Энэхүү журмыг зөрчсөн буруутай албан хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.